

**Ерөнхий мэргэжлийн эмчийн мэргэжлээр эмчлэх зөвшөөрөл олгох шалгалтын  
жишиг сорил**

**Хувилбар -7**

**1.Нэг сонголттой тест ( Зөвхөн 1 хариулт зөв байх )** Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.

**2.Олон сонголттой тест ( Хэдэн ч хариулт зөв байж болох )**

1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)

1 ба, 3 дугаар хариултууд зөв бол (B.)

2 ба 4 дугаар хариултууд зөв бол (C.)

Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)

Бүх хариулт зөв бол (E.)

**3.Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)**

Зөв, Зөв, Зөв (A.)

Зөв, Зөв, Буруу (B.)

Зөв, Буруу, Буруу (C.)

Буруу, Зөв, Буруу (D.)

Буруу, Буруу, Буруу (E.)

/1./ Уушгины архаг бөглөрөлт өвчний хувьд тохирохгүй шинжийг сонгоно уу:

A. Тамхи татдаг хүмүүст уушгины архаг бөглөрөлт өвчин үүсэх эрсдэл татсан тамхины тооноос хамаардаг

B. Жилд татсан тамхины тоо уушгины архаг бөглөрөлт өвчин үүсэх эрсдэлтэй шууд хамааралтай

C. Идэвхигүй тамхидалт уушгины архаг бөглөрөлт өвчнийг үүсгэхгүй

D. Уушгины архаг бөглөрөлт өвчтэй хүмүүсийн тамхи татсан үзүүлэлт ихэвчлэн дор хаяж 20 хайрцаг\жил байдаг

E. Тамхи татдаг хүмүүс татдаггүй хүмүүстэй харьцуулахад уушгины архаг бөглөрөлт өвчнөөр илүүтэй өвдөж, нас бардаг

/2./ Дараахаас аль нь үнэн бэ?

A. Уушгины архаг бөглөрөлт өвчний үед ингаляцийн кортикостероиддыг дангаар \удаан үйлдэлтэй гуурсан хоолой тэлэгч эмгүй\ хэрэглэхийг зөвлөхгүй

B. Ингаляцийн кортикостероидыг  $FEV_1 \geq 80\%$  өвчтөнд хэрэглэнэ

C. Хүндэвтэр зэргийн уушгины архаг бөглөрөлт өвчинтэй хүнд удаан хугацааны туршид системийн кортикостероид хэрэглэнэ

D. Уушгины архаг бөглөрөлт өвчний сэдрэлийн үед кортикостероидыг хэрэглэхгүй

E. Уушгины архаг бөглөрөлт өвчний үед ингаляцийн кортикостероидыг аль болох эрт хэрэглэнэ

/3./ Уушгины үрэвслийн нийтлэг бус үүсгэгч юу вэ?

1. Микоплазм

2. Легионелл

3. Хламиди

4. Томуугийн вирус

5. Цитомегаловирус

/4./ Гуурсан хоолой тэлэгдэх өвчний эмчилгээний үндсэн аргыг нэрлэнэ үү:

1. Байрлалын дренаж

2. Хордлого тайлах

3. Доргионт массаж

4. Дархлаа дэмжих

5. Цэр шингэлэх

/5./ Анафилаксийн үед медиаторууд ямар эсээс ялгарах вэ?

A. Эозинофил

B. Т-лимфоцит

C. Цулцангийн макрофаг

- D. В-лимфоцит  
E. Хөөнгө эс
- /6./ Уушгины дэлбэнгийн үрэвслийн үед ямар шинж тодорхойлогдох вэ?  
1. Амьсгал эрс сулрах, эсвэл сонсогдохгүй байх  
2. Бронхофони ба дууны доргион ихсэх  
3. Тогшиход хэргэргэн дуутай байх  
4. Гуурсан хоолойн амьсгал сонсогдох  
5. Бронхофони ба дууны доргион сулрах
- /7./ Уушгины сүрьеэ үүсэхэд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйл бол:  
1. Ходоод, дээд гэдэсний шархлаа  
2. Чихрийн шижин  
3. Силикоз  
4. Лимфогранулематоз  
5. Артерийн гипертензи
- /8./ Анхдагч сүрьеэгийн үед үүссэн шүүдэст плевритын хувьд дараахаас бусад нь онцлог байдаг  
A. Залуу насанд илүүтэй тохиолдоно  
B. Сүрьеэгийн эсрэг эмчилгээг гялтангийн хөндийд шингэн байх үед л хийнэ  
C. Экссудат серозон шинжтэй  
D. Шингэнд лейкоцит цөөн, лимфоцит давамгайлна  
E. Уушгинд өөрчлөлт илрээгүй байна
- /9./ Мантугийн сорилыг тавихдаа туберкулиныг яаж хэрэглэх вэ?  
A. Цагаан мөгөөрсөн хоолойд цацна  
B. Арьсанд тарина  
C. Арьсан дор тарина  
D. Судсанд тарина  
E. Арьсан дээр хэрэглэнэ
- /10./ Цээжний хөндийн хоёр талын лимфаденопати ямар өвчний үед илэрч болох вэ?  
1. Саркоидоз  
2. Лимфогранулематоз  
3. Лимфом  
4. Гистиоцитоз Х  
5. Силикоз
- /11./ Бөөрний цочмог дутагдлын үед зайлшгүй хийх шинжилгээг нэрлэнэ үү?  
1. Цусан дах креатинин  
2. Цусны PH үзэх  
3. Цусны электролит үзэх  
4. Зимницкийн сорил  
5. Шээсэн дэх давсны агууламж
- /12./ Доплерт сонографи дараахь тохиолдлоос нэгээс бусдад хийх шаардлагатай.  
A. Бөөрний хавдар  
B. Шалтгаан тодорхойгүй шээс цустах  
C. Шалтгаан тодорхойгүй даралт ихсэх  
D. Архаг гломерулонефрит  
E. Бөөрний унжилт
- /13./ Хүүхэд шөнө орондоо шээхийг юу гэж нэрлэх вэ?  
A. Олигоури  
B. Дизури  
C. Никтури  
D. Странгури  
E. Энурез
- /14./ Гематурийг шалтгаанаар яаж ангилдаг вэ ?  
1. Пререналь  
2. Реналь  
3. Постреналь  
4. Түүдгэнцрийн

5. Аяганцар тэвшинцэрийн
- /15./ Хоёрдогч пиелонефритийн үед доорхи шинжүүдээс нэгээс бусад нь илэрнэ
- Дизури
  - 1мл шээсэнд 100000-аас дээш нян илэрнэ
  - Бөөрний аяганцар тэвшинцэрийн деформаци
  - Түүдгэнцэрийн шүүлт буурах
  - Сувганцаэрын эргэн шимэгдэлт буурах
- /16./ Гликокаликс гэж аль ойлголтыг нэрэлдэг вэ
- Подоцитийн элемент
  - Мезангиумын элемент
  - Суурин мембраны хасах цэнэгтэй хэсгүүд
  - Ялгаруулах аппарат
  - Ренин
- /17./ Транзитор уураг алдалт нь дараах тохиолдолд илэрнэ
- Биеийн эмгэг галбир
  - Даарч хөрөх
  - Биеийн хүчний хүнд ажил хийх
  - Удаан хугацаагаар халуурах
  - Фитнес хийх
- /18./ Архаг гломерулонефритийн үед гормон эмчилгээ хийх заалт
- Гематури
  - Артерийн даралт ихсэлт
  - Бөөрний архаг дутагдал
  - Нефроз хам шинж
  - Сэдрэлээс сэргийлэх зорилгоор
- /19./ Пиелонефритийн хамгийн түгээмэл тохиолдох үүсгэгч нь аль вэ?
- Стрептококк
  - Клебсиелл
  - Бактерууд
  - Гэдэсний савханцар
  - Вирусууд
- /20./ Архаг гломерулонефритийн даралт ихдэх хэлбэрийн сэдрэлийн үед дараах нэг шинжээс бусад нь илэрнэ.
- Протеинури
  - Гематури
  - Цилиндрури
  - Хаван
  - Артерийн даралт ихсэлт
- /21./ шээсэнд 3 Сар ба түүнээс удаан хугацаанд уураг илэрсэн тохиолдолд Бөөрний архаг өвчинг оношлоно. Иймд Бөөрний архаг өвчинг шээсэн дэхь уургийн хэмжээгээр нь 2 үе шат болгон ангилдаг.
- /22./ СРТ нь бөөрний эмгэг судлалын практикт өргөн хэрэглэгддэг хоёр бөөрний үйл ажиллагааг харьцуулан судалдаг рентген шинжилгээний арга мөн.
- /23./ Цэсний сөөргөөт гастритын үед амьд сорьцын эмгэг бүтцийн шинжилгээнд ямар өөрчлөлт гарах вэ?
- Үрэвслийн эсийн нэвчдэс, шалбархай, өнгөц шарх, эсийн гэмтэл
  - Салстын дорх цус харвалт, эсийн гэмтэл, лимфоцит эсийн нэвчдэс
  - Хонхорхойн гиперплази, ходоодны өөрийн ялтас хөөсөн, цус дүүрсэн, лимфоцит, плазмоцит, лаброцит эсийн нэвчдэс
  - Хонхорхойн гиперплази, шалбархай, өнгөц шарх, эсийн гэмтэл
  - Эсүүд хөөсөн, гэдэсний метапази, хатингаршил
- /24./ Цэсний ялгаралтыг идэвхижүүлдэг гормон аль нь вэ?
- Глюкагон

- B. Адреналин
- C. Холецистокинин
- D. Кортизол
- E. Инсулин

/25./ Архаг энтретийн үед биохимийн шинжилгээнд илрэхгүй шинж нь аль вэ?

- A. Сийвэнд агуулагдах уураг
- B. Альбумин
- C. Өөх тос
- D. Эрдэс бодис
- E. Нүүрс ус

/26./ Элэгний энцепалопатийн үед тоо холбох тестийг энцепалопатийн 1-2 зэрэгтэй хүн хэдэн секундэд биелүүлэх вэ?

- A.  $\leq 30$
- B. 31-50
- C. 51-80
- D. 81-120
- E.  $120 \leq$

/27./ D хепатитийн вирус нь дараах вирусгаар халдварлагдсан үед элэгний эсэд нэвтрэн элгийг үрэвсүүлнэ:

- A. Вирус А
- B. Вирус С
- C. Вирус В

/28./ Барретийн улаан хоолойн шалтгааныг дурдана уу?

1. Төрөлхийн эмбриогенезийн чанартай
2. Төрөлхийн богино улаан хоолой
3. Өрц, улаан хоолойн эвэрхий
4. Ахалази
5. Ходоод улаан хоолойн сөөргөө өвчин

/29./ Ходоод, дээд гэдэсний III хэлбэрийн байрлалтай шархлаанд ходоодны ямар хэсгийн шархлаанууд хамаардаг вэ?

1. Нугалуурын
2. Бага махир
3. Нугалуурын өмнөх
4. Их махир
5. Ходоодны дээд өнцөг

/30./ Нойр булчирхайн цочмог үрэвслийн үед эрт илрэх, хүндрэл аль нь вэ?

1. Уушигны гялтанд шингэн хурах
2. Чихрийн шижин
3. Буглаа
4. Нойр булчирхайд хуурамч уйланхай үүсэх
5. Элэгний дутагдал

/31./ Литотрипси хийсний дараа ямар хүндрэл гарах вэ?

1. Цэсний ерөнхий цорго гэмтэх
2. Транзитор цэсний хатгаа
3. Цэсний ерөнхий сорвижих
4. Панкреатит
5. Цэсний хүүдий цоорох

/32./ Суулгалт зогсоох үйлчилгээт эмийг сонгоно уу?

1. трихопол
2. сульфасалазин
3. фестал
4. имодиум
5. метоклопрамид

/33./ Цэсний цоргонд саад үүссэн үед баас цагаан гарна. Учир нь холбоот билирубин гэдэс рүү ордоггүй

/34./ Нарийн гэдсэнд хоол боловсролт хөндийн ба ханын хоол боловсруулалт, шимэгдэлт гэсэн 3 үе шаттай явагдана. Эдгээрт энтероцит эсээс ялгарах ферментээс гадна гэдэсний шүүсэнд агуулагдах ферментүүд оролцоно.

/35./ Глюкагон дараах үйлдэлтэй.

- A. Липолизыг багасгана
- B. Гексокиназа ферментийн үйл ажиллагааг идэвхижүүлнэ
- C. Гликогенезийг ихэсгэнэ
- D. Глюконеогенезийг багасгана
- E. Гликогенолизыг ихэсгэнэ

/36./ ЧШ-гийн кетоацидозын үед доорх шинж тэмдэгүүдийн аль нь илрэхгүй вэ?

- A. глюкозын зарцуулалт буурах
- B. цусанд глюкоз ихсэх
- C. өөх тосны задрал багасах
- D. уургийн задрал ихсэх
- E. осмос диурез

/37./ Гипокортицизмын шалтгааныг нэрлэ

- A. Гүйлгэх
- B. Сүрьеэ
- C. Өндгөвчний хавдар
- D. Олигоменоррей
- E. Глюкокортикостерома

/38./ Тархмал хордлогот бахуугийн хордлогын хөнгөн зэргийн үед хэрэглэх тиреостатик эмийн тунг тогтооно уу

- A. Мерказолил хоногт 20-30мг
- B. Мерказолил хоногт 30-40мг
- C. Мерказолил хоногт 5-10мг
- D. Мерказолил хоногт 15-20мг
- E. Мерказолил хоногт 40-60мг

/39./ Таргалалтын эмчилгээг сонгоно уу

- A. Хоол эмчилгээ
- B. Хөдөлгөөн эмчилгээ
- C. Эмийн эмчилгээ
- D. Мэс заслын эмчилгээ
- E. Дээрх бүгд орно

/40./ Эутириозын үед цусан дахь Т3, Т4, ТТГ-ын хэмжээ

- 1. Т4 хэвийн
- 2. Т3 хэвийн
- 3. ТТГ хэвийн
- 4. Т4 ихэснэ
- 5. Т3 багасна

/41./ Иод дутлын эмгэгийн үед дааврын талаас ямар өөрчлөлт гарах вэ?

- 1. Тиролиберин буурна
- 2. Т3, Т4 буурна
- 3. Тиреоглобулин ихэснэ
- 4. Тиреотропин ихэснэ
- 5. Т3 буурч, Т4 ихэснэ

/42./ Гиперкортицизмын үед кортикостероидуудын ялгарал ихэснэ. Учир нь гиперкортицизмийн үед рецепторын зохицуулга алдагддаг.

/43./ Артерийн гипертензийн үед үзүүлэх яаралтай тусламжтай холбоотой зөв хариултыг сонгох

- 1. Таван минутын дотор артерийн даралдтыг бууруулах
- 2. Тархины хаванг багасгах зорилгоор маннитол хэрэглэн

3. Хэлэн дор нифедипин тавина
4. Нитропруссидыг судсаар дусааж тарина
5. Лабеталолыг судсаар тарих нь үр дүнтэй

/44./ Бөөрний эдийн эмгэгийн үед простагландин багасдаг. Простагландин судас тэлж, АД бууруулдаг

/45./ ST сегмент өргөгдөөгүй зүрхний шигдээсийг тогтворгүй стенокардигаас ялгахын тулд ямар шинжилгээ хийх хэрэгтэй вэ?

- A. Зүрхний цахилгаан бичлэг
- B. Зүрхний хэт авиан шинжилгээ
- C. Нийт КФК, ЛДГ
- D. Тропонин
- E. Коронарны ангиографи

/46./ Зүүн ховдлын цочмог дутагдлын эмчилгээнд алийг нь сонгох вэ?

1. Морфин булчинд тарина
2. Хүчилтөрөгч маскаар өгнө
3. Тиазидын бэлдмэл хэрэглэнэ
4. Хүнд тохиолдолд аппаратаар амьсгалуулах
5. Өвчтөнийг намхан дэртэй байрлуулна

/47./ Митрал хавхлагын нарийслын үед зүрхний цахилгаан бичлэгт илэрдэг өөрчлөлтийг сонгох

1. Тосгуурын мерцани
2. Зүүн ховдлын томрол
3. Зүүн тосгуурын томрол
4. Гисийн баруун салааны хориг
5. Цахилгаан тэнхлэг зүүн тийш хазайна

/48./ Митрал хавхлагын нээлтийн талбайн хэвийн хэмжээг сонгоно уу?

- A. 2.0-2.5 см<sup>2</sup>
- B. 2.5- 3.0 см<sup>2</sup>
- C. 3.5 -4.0 см<sup>2</sup>
- D. 3.0-3.5 см<sup>2</sup>
- E. 4.0-6.0 см<sup>2</sup>

/49./ Дараах эмгэгүүдээс аль нь зүрхний гэнэтийн үхлийн шалтгаан болох вэ?

1. Титэм судасны цочмог хам шинж
2. Вирусны миокардит
3. Гиперкалиеми
4. Кардиомиопати
5. Вольф-Паркинсон-Вайтын хам шинж

/50./ Ямар ч өвдөлтгүй, эмнэл зүйн илрэлгүй хүмүүст титэм судасны эмгэгийг илрүүлэх зорилгоор эмийн сорилтой зүрхний хэт авиан оношлогоо хийдэг. Ямар эмийн бэлдмэлийг энэхүү сорилд түлхүү ашигладаг вэ?

- A. Пропроналол
- B. Добутамин
- C. Атропин
- D. Допамин
- E. Нитроглицерин

/51./ Гипертензийн кризын үед АД-н түвшинг эхний 2 цагт хэдэн хувиар бууруулвал тохиромжтой вэ?

- A. 20%-р
- B. 35%-р
- C. 10%-р
- D. 15%-р
- E. 25%-р

/52./ Стенокардийн өвдөлтийг ямар эмгэгээс ялган оношлох хэрэгтэй вэ?

1. Хавирга завсрын невральги

2. Кардиоспазм
  3. Кардиальги
  4. Зүрхний үрэвсэлт өвчнүүд
  5. Зүүн талын пневмони
- /53./ Нитроглицерины гол гаж нөлөөг заана уу
- A. Бөөлжис цутгах
  - B. Суулгах
  - C. Ханиалгах
  - D. Толгой өвдөх
  - E. Хоолонд дүргүй болох
- /54./ Шинэ хөлдөөсөн сийвэн хэрэглэх заалтыг нэрлэнэ үү?
1. Цус бүлэгнэлтийн хүчин зүйлийн дутагдал
  2. Витамин К-ийн дутагдал
  3. Судсанд цус түгмэл бүлэгнэх хам шинж (ДВС)-ийн үед
  4. Их хэмжээний цус сэлбүүлсэн өвчтөнд
  5. Элэгний өвчнүүдийн үед цус алдаж байгаа тохиолдолд
- /55./ Төмөр дутагдлын үеийн цус төлжилтийн үеийг сонгоно уу?
- A. Төмөр дутагдлын цус багадалтын үеийн эмнэлзүй, лабораторын шинж илрэх үе
  - B. Сийвэнгийн Fe багасаж, гемоглобин хэвийн байх
  - C. Сийвэнгийн ферритин багасаж, Fe, гемоглобин хэвийн байх
  - D. Сийвэнгийн ферритин багасаж, төмөр ихсэх
  - E. Сийвэнгийн төмөр ихсэж, ферритин ихсэх
- /56./ Миелофиброз өвчний сэжиглэж байгаа тохиолдолд оношийг батлах шинжилгээ аль нь вэ?
1. Ясны хэмийн эдийн шинжилгээнд цус төлжүүлэх эсүүдийн хэсэг бөөгнөрөл нь холбогч эдэн ретикулины бүдүүн ширхгүүдтэй хамт алаг цоог харагдана. Цитогенетикт хромсомын гажууд илэрнэ.
  2. Ясны хэмийн эсийн шинжилгээнд мегакариобласт 30%-с их
  3. MRI-д холбогч эд ихтэй ясны хэмийг, ЭХО-д дэлүүнд үүссэн холбогч эдэн голомтыг илрүүлэх
  4. Гавлын ясны рентгенд остеолизын голомтыг илрүүлэх
  5. Ясны хэмийн эсийн шинжилгээнд миелобластуудыг илрүүлэх
- /57./ Удамшлын микросфероцитоз өвчний үед гарах өвөрмөц шинжүүдээс аль шинж нь орохгүйг дурдана уу?
- A. Нахиу хамар
  - B. Хүнхэр тагнай
  - C. Хуруугүй төрөх
  - D. Шүдний хэлбэр өөрчлөгдсөн
  - E. Хөл шилбээрээ майга
- /58./ Аутоиммун тромбоцитопени тэй өвчтөнд дэлүү авах заалт:
- A. Иммунодепрессант эмүүд хэрэглэсэн ч үр дүнгүй байгаа тохиолдолд
  - B. Гормон эмчилгээнд үр дүнгүй, жилд 2-3 удаа сэдрэл өгч байгаа тохиолдолд
  - C.  $\alpha 2$ -интерферон эмчилгээнд үр дүнгүй байгаа тохиолдолд
  - D. Полихими эмчилгээ үр дүнгүй байгаа тохиолдолд
  - E. Монохими эмчилгээ үр дүнгүй байгаа тохиолдолд
- /59./ Түгмэл миеломын аль хэлбэрийн үед сийвэнгийн нийт уураг ихсэхгүй вэ?
- A. Түгмэл миелома А
  - B. Түгмэл миелома G
  - C. Түгмэл миелома D
  - D. Түгмэл миелома M
  - E. Түгмэл миелома E
- /60./ Ферроплексийн төмрийн агууламжийг сонгоно уу?
- A. 10мг
  - B. 162мг
  - C. 150мг
  - D. 100мг

- Е. 50мг
- /61./ Цус алдалтын үед цусны сийвэнгийн хэдэн хувийг алдахад бие хүн амьдрах боломжгүй вэ?
- 80%
  - 60%
  - 30%
  - 40%
  - 15%
- /62./ Төрсөн эхэд ямар шинж илэрвэл яаралтай тусламж хэрэгтэй вэ?
- Ухаангүй эсвэл татах.
  - Цус алдаж байгаа эсвэл хэвлийгээр хүчтэй өвдөх.
  - Толгой өвдсөн эсвэл нүдний харах байдал өөрчлөгдөх.
  - Маш их бэрхшээлтэй амьсгалах эсвэл халуурах.
  - Их хэмжээгээр бөөлжих.
- /63./ Жирэмсэн үед бэлэг эрхтэнд дараах физиологийн өөрчлөлтүүд илэрнэ:
- Үтрээний салст хөхөлбөр болно;
  - Бэлгийн уруулын тосны булчирхай шүүрэл ялгарал ихсэнэ
  - ГБЭ хөөнгөтнө
  - Хэлүү томорно
  - Хярсан төмбийнө
- /64./ Төрөх өрөөнд зайлшгүй байх эмийг нэрлэнэ үү
- Гентамецин
  - Нитроглицерин
  - Кетамин
  - Сальбутамол
  - Индометацин
- /65./ Төмрийн бэлдмэлийг хэвийн явцтай жирэмсэнд яаж уулгах вэ?
- Жирэмсний турш өдөрт хагас шахмалыг ууна.
  - Өдөрт хагас шахмалаар 3 сарын турш ууна.
  - Жирэмсний турш өдөрт 1 шахмалыг ууна
  - Өдөрт 2 удаа 1 шахмалаар жирэмсний турш ууна.
  - Өдөрт 2 шахмалаар 3 сарын турш, залгаад жирэмсний турш 1 шахмалаар ууна.
- /66./ Ургийн жинг тодорхойлох Бубличенкогийн арга гэж юу вэ?
- Эхийн биеийн жингийн 20/1-тэй тэнцүү
  - Гэдэсний эргэн тойрон умайн ёроолын өндөрийн үржвэртэй тэнцүү
  - Умайн ёроолын өндөртэй тэнцүү
  - Гэдэсний эргэн тойронг 2-т хуваасантай тэнцүү
  - Умайн ёроолын өндөрийг 2-оор үржүүлсэнтэй тэнцүү
- /67./ Зүүн ховдолд агшилтын даралт өндөр болох нь аль тохиолдолд вэ?
- 2 хавтаст хавхлагын дутагдал
  - Гол судасны хавхлагын нарийсал
  - 2 хавтаст хавхлагын нарийсал
  - Гол судасны хавхлагын дутагдал
  - 2 хавтаст ба гол судасны хавхлагын нарийсал
- /68./ Спонтанный пневмотораксыг оношлоход ямар шинжилгээ хэрэглэх вэ?
- Ирригоскопи
  - Цээж гэрэлд харах
  - Медиастеноскопи
  - Торакотоми
  - Лапароскопи
- /69./ Цээжний гялтангийн үрэвслийг зонхилон үүсгэдэг шалтгааныг заана уу.
- Гаднаасхалдвар орох
  - Цус - буюу тунгалагийн халдвар
  - Үжлийн халдвар
  - Зэргэлдээ эрхтэнээс халдвар дамжих
  - Мөгөөрсөн хоолойгоорхалдвар орох



/70./ Гэмтсэн өвчтөн амь тэнссэн байдалд орсон шинжүүдэд хамаарахыг нь тэмдэглэнэ үү?

1. Ухаангүй
2. Амьсгал саадтай (хяхнасан амьсгал)
3. Амьсгалын тоо хэт цөөрсөн, олширсон, давчидсан
4. Амьсгалын хөдөлгөөн ажиглагдахгүй
5. Их хэмжээний цус алдсан

/71./ Өвчтөн амь тэнссэн байдалд ороогүй хөнгөвтөр гэмтэл авсан үед анхааран ажиллах хамгийн чухал зүйл юу вэ?

- A. Гэмтлийн байрнаас зөөж холдуулах
- B. Ар гэрийнхэнд мэдэгдэх
- C. Ажлын газарт нь дуулгах
- D. Өвчтөний биеийн байдлыг хүндрүүлж болох гэмтлийг илрүүлж анхны тусламж үзүүлэх
- E. Ойрын эмнэлэгт тээвэрлэн хүргэх

/72./ 62 настай эрэгтэй 3 сарын өмнөөс ходоодны хорт хавдар нь элгэнд үсэрхийлэл өгсөн гэж оношлогдсон тул илаарших боломжгүй гэж гэрт нь гаргасан, хөнгөвчлөх эмчилгээнд хамрагдахыг зөвлөсөн. Сарын өмнөөс түүний аюулхай орчим байнга халуу шатах мэт өвддөг болсон тул Диклоденк уудаг эсвэл шулуун гэдэсний лаагаар хэрэглэдэг. Түүний өвдөлт сүүлийн хоногуудад ихсэж, инээмсэглэхээ больсон ба Диклоденк үйлчлэхээ больсон. Түүний өвдөлтийг ангилна уу.

1. Архаг
2. Байнгын
3. Невропатик
4. Носисептив
5. Холимог

/73./ Бисакодил ямар үйлчилгээтэй туулга вэ?

- A. Гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөнийг ихэсгэдэг
- B. Баасыг гулгамтгай гөлгөр болгодог
- C. Осмос даралтаар гэдсэнд шингэнийг татдаг тул баасыг шингэрүүлдэг
- D. Ходоодонд хөөж өтгөний хэмжээ, эзэлхүүнийг ихэсгэдэг
- E. Өтгөний наалдамхай, зунгааралдсан чанарыг багасгадаг

/74./ Нүд хөдөлгөгч мэдрүүлүүд

1. N.oculomotor
2. N.maxillar
3. N.abducens
4. N. mandibular
5. N.facial

/75./ Ахмад настай эрэгтэй хүнд юм өргөх үед цээжээр хатгаж, амьсгаа авах, найтах, ханиахад түвэгтэй. Зүрхний бичлэг хэвийн. АД 130/80мм.МУБ. Таны урьдчилсан онош:

- A. Ёзоор татагдлын өвдөлт
- B. Зүрхний бах
- C. Уушигны багтраа
- D. Бүсэлхийн радикулопати
- E. Архаг бронхит

/76./ Хүүхдийн сүрьеэгийн оношлогоонд хэрэглэх гол шинжилгээний аргуудыг нэрлэнэ үү?

1. Цэрний шинжилгээ
2. Гэрлийн шинжилгээ
3. Томографийн шинжилгээ
4. Туберкулины сорил
5. Эдийн шинжилгээ

/77./ Уушигны голомтот сүрьеэгийн үед бодит үзлэгт ямар өөрчлөлтүүд илрэх вэ ?

1. Цээжний хэнхэрцэг өөрчлөлтгүй
2. Тогшилтоор болон чагналтаар онц өөрчлөлтгүй
3. Цээжний хэнхэрцэг 2 талд амьсгалд жигд оролцоно
4. Их хэмжээний хуурай нойтон хэржигнүүр сонсогдоно
5. Цээжний хэнхэрцэг торх хэлбэртэй болсон байна

/78./ Сүрьеэгийн нянгийн үржлийг дарангуйлдаг эмийн бэлдмэлийг нэрлэнэ үү?

- A. Изониазид
- B. Рифамицин
- C. Этамбутол
- D. Пиразинамд
- E. Стрептомицин

/79./ БЦЖ вакцины сорви ямар хэмжээтэй байвал үр дүнтэй дархлал тогтсон гэж үзэх вэ?

- A. 2 мм
- B. 4-6 мм
- C. 16 мм
- D. 1 мм
- E. Дээрхи бүгд

/80./ Риновирусийн халдварын тодорхойлолтыг тэмдэглэнэ үү?

A. Ерөнхий хордлогын хам шинж болон амьсгалын замын үрэвслийн хам шинжээр илэрдэг цочмог халдварт өвчнийг хэлнэ.

B. Хамрын салстын үрэвсэл давамгайлсан, ерөнхий хордлогын хам шинж багатай явагддаг амьсгалын замын цочмог халдварт өвчнийг хэлнэ.

C. Хамрын салстын үрэвсэл болон амьсгалын замын үрэвслийн хам шинжээр илэрдэг цочмог халдварт өвчнийг хэлнэ.

D. Хамрын салстын үрэвсэл болон суулгах хамшинжээр илэрдэг амьсгалын замын цочмог халдварт өвчнийг хэлнэ.

E. Амьсгалын доод замын үрэвсэл болон хамрын салстын үрэвсэл, суулгах хам шинжээр илэрдэг цочмог халдварт өвчнийг хэлнэ

/81./ Сахуу өвчний нууц хугацаа хэд хоног вэ?

- A. 1-7 хоног
- B. 2-10 хоног
- C. 5-14 хоног
- D. 14-28 хоног
- E. 30-60 хоног

/82./ Балнад өвчний үед тохиолдох онцлог шинжүүдийг сонгоно уу?

1. Өнгөртэй зузаан хэл
2. Падалкийн шинж
3. Филлипповичийн шинж
4. Стефанскийн шинж.
5. Гиппократын царай

/83./ Бичил биетнийг эмгэг төрүүлэгч чадвараар нь хэдэн бүлэгт хуваадаг вэ?

1. Эмгэг төрүүлэгч,
2. Эмгэг бус төрүүлэгч,
3. Болзолт эмгэг төрүүлэгч
4. Нян
5. Вирус

/84./ Блефаритийн хэлбэрийг нэрлэнэ үү.

1. Энгийн
2. Хайрст
3. Шархлаат
4. Хэсэг газрын
5. Үрэвсэлт

/85./ Мөөгөнцөрт кератитийн үед ямар шинжилгээ ач холбогдолтой вэ?

1. Бактериологийн шинжилгээ
2. Нүдний ЭХО
3. Амьтанд тарьж турших
4. Харааны талбайн шинжилгээ
5. Нүдний уг дурандах

/86./ Нистагм, төрөлхийн катаракт, торовчийн нөсөөт хувьсал, харааны мэдрүүлийн атрофи хавсран илрэх хам шинжийг нэрлэнэ үү

- A. Лангтон Дауны өвчин
- B. Ромбергийн синдром

- C. Бурневилийн хам шинж
- D. Фридрайхын хам шинж
- E. Горнерийн хам шинж

/87./ Хамрын харшилт хэлбэрийн хувьсуурт нусгайн үед илрэх эмнэлзүйн шинжийг олно уу

- A. Хамар битүүрэх, хамраас өтгөн ногоон нус гарах, үе үе найтаах
- B. Хамар битүүрэх, самалдгууд томорч улайх
- C. Хамар битүүрэх, өтгөн ногоон нус гарах, нүүр өвдөх
- D. Хамар битүүрэх, нүүр толгой өвдөх, таславч мурий байх
- E. Хамар битүүрэх, хамраас шингэн нус гоожих, угсруулан найтаах

/88./ Ангины алсын хүндрэл аль нь вэ?

- 1. Үжил
- 2. Ревмокардит
- 3. Артриты
- 4. Псориаз
- 5. Гломерулонефрит

/89./ Бага насны хүүхдэд хамрын таславч дахь өсөлтийн бүс хөгжөөгүй байдаг (1) тул нүүрний өсөлт зогсохоос сэргийлж таславчийн хагалгаанаас зайлсхийдэг (2).

/90./ 62 настай малчин эмэгтэй баруун өвдөг рүү хатгуулж өвддөг болсон зовиуртай. Өвдөг ялангуяа шөнийн цагаар их өвддөг. Тэр мал төл авах, хонь түрүүлэх ажил хийдэг ба бээлийгүй гараараа зулбасан малын эхэс хуулдаг байсан гэв. Түүний ээж 78 настайдаа нугасанд сүрьеэгийн хүйтэн буглаатай, өвдөгний сүрьеэтэй байгаад ХӨСҮТ-ийн сүрьеэгийн тасагт 10 жилийн өмнө нас барсан. Нөхөр нь булчирхайн сүрьеэгээр өвчилж, хүзүүний булчирхайнаас идээрхэг шингэн гойжсон тул мэс засал хийлгэж, булчирхайг авахуулсан. Эмэгтэй өөрөө туранхай, хөлрөмтгий, ядрамтгай. Рентген зурагт баруун өвдөгний яс голомтот эмтэрсэн өөрчлөлттэй, зүүн өвдөг остеоартритын шинжтэй. Түүнд ямар өвчин байх магадлал илүү өндөр байна вэ?

- A. Хэрх өвчин
- B. Баруун өвдөгний ясны сүрьеэ
- C. Остеоартрит
- D. Тулай
- E. Шенлейн Генохын өвчний үе мөчний хэлбэр

/91./ Насжилттай холбоотой зүрх судасны тогтолцоонд үйл ажиллагааны ямар өөрчлөлт илэрдэг вэ?

- 1. Зүрхний агшилтын хүч буурна
- 2. Зүрхний агшилтын давтамж буурна
- 3. Зүрхний зүүн ховдлын хана зузаарч, хавхлага хаагдах нь удааширна
- 4. Зүрхний зүүн ховдол зузаарах тул агшилтын хүч ихсэнэ
- 5. Зүрхний цохилт олшроно

/92./ 76 настай өвгөн шөнө босч шээдэг болсон тул нойр алдаад байна гэсэн зовиуртай өрхийн эмчид хандав. Тэр шатаар явах үед амьсгааддаг байсан бол одоо тайван байх үедээ ч амьсгааддаг болсон. Тэр өглөө сэрэхэд хавангүй хэрнээ, орой болоход хоёр шилбэ, шагайгаар хавансан байдаг. Шөнө босч шээдэг болсон гэж өгүүлсэн байв. Түүний хаван ямар шалтгаантай үүссэн байх магадлал өндөртэй вэ?

- A. Бөөрний өвчний шалтгаантай хаван
- B. Зүрхний дутагдлын шалтгаантай хаван
- C. Тунгалгын хаван
- D. Элэгний дутагдлын ба үүдэн венийн даралт ихссэнтэй холбоотой хаван
- E. Уураг дутагдлын хаван

/93./ Остеоартрит ямар үе шаттай явагддаг вэ?

- 1. Эхний шатанд үений мөгөөрс илэгдэж, нимгэрдэг.
- 2. Дараагийн шатанд элэгдсэн яснаас простогландин мэтийн үрэвслийн медиатор ялгарна.
- 3. Дараагийн шатанд үрэвслийн медиатор үений шингэнд хуримтлагдсаар үрэвсэл үүсч, үе хавагнах, өвдөх шинж үүсгэнэ.

4. Үений шингэнд шээсний хүчил хуримтлагдаж, үе хавдаж, үрэвсэж, өвдөнө.
5. Үений ясанд хүүтэн буглаа үүснэ.
- /94./ Эрхтэн тогтолцооны хатуурлын эмнэлзүйн шинжүүдийг нэрлэнэ үү:
1. Арьс хатуурах
  2. Рейно хам шинж
  3. Уушигны гипертензи
  4. Уушигны фиброз
  5. Үений үрэвсэл
- /95./ Нурууны барьцалдуулах үрэвсэлд хамааралтай хам шинжүүдийг тодорхойлно уу:
1. 7-15 насны хүүхдүүдэд зонхилон тохиолдох
  2. Залуу эрэгтэйчүүдэд зонхилон тохиолдох
  3. Өглөөний хөшингө 30 мин
  4. Нурууны бүсэлхийн өвдөлт 3 сараас урт хугацаанд үргэлжлэх
  5. Эрүүний үе хавдах, өвдөх
- /96./ Цэвэршилтийн дараахь эмэгтэйн хэрэглэх кальцийн өдрийн тун:
1. 700мг
  2. 1000мг
  3. 1200 мг
  4. 1500 мг
  5. 2000 мг
- /97./ Яс үений үрэвслийн (Osteoarthritis) үед үений хэлбэр алдалтыг нэрлэнэ үү.
1. Үе гипертрофи болох
  2. Vagus
  3. Varus
  4. Богтосруу хазайх
  5. Үе атрофи болох
- /98./ Хэрх өвчний эмнэлзүйд тохирохыг сонгоно уу.
1. Жижиг үеийг хамрах
  2. Цагираг улайлт
  3. Өглөөний хөшингө 1 цаг
  4. 2 талдаа ижил бус байх
  5. Үений хэлбэр алдагдах
- /99./ Тохойн үеийг тэмтрэх зөв аргыг заана уу.
- A. Тохойг 90 хэмийн өнцгөөр нугалж барина.
  - B. Тохойг сул чөлөөтэй 110 хэмийн өнцгөөр нугалж тэмтрэнэ.
  - C. Тохойг сул чөлөөтэй 90 хэмийн өнцгөөр эмч 2 гараараа дэмжин барина.
  - D. Эмч нэг гараар тохойг дурын өнцгөөр тэмтрэнэ.
  - E. Тохойг эргүүлж тэмтрэнэ.
- /100./ Яс нь холбогч эдийн нэг төрөл бөгөөд эс завсрын кальцижсанүндсэн бодис ясны матрикс болон таван төрлийн эсээс тогтоно.

### **Сорилын зөв хариулт**

1-С, 2-А, 3-А, 4-В, 5-Е, 6-С, 7-А, 8-В, 9-В, 10-А, 11-А, 12-Д, 13-Е, 14-А, 15-Д, 16-С, 17-Е, 18-Д, 19-Д, 20-Д, 21-С, 22-Е, 23-С, 24-С, 25-Е, 26-С, 27-С, 28-Е, 29-В, 30-В, 31-С, 32-Д, 33-А, 34-А, 35-Е, 36-С, 37-В, 38-Д, 39-Е, 40-А, 41-С, 42-С, 43-Д, 44-А, 45-Д, 46-С, 47-В, 48-Е, 49-Е, 50-В, 51-Е, 52-Е, 53-Д, 54-Е, 55-В, 56-В, 57-А, 58-В, 59-С, 60-А, 61-С, 62-Е, 63-А, 64-Е, 65-С, 66-А, 67-В, 68-В, 69-Д, 70-Е, 71-Д, 72-А, 73-А, 74-В, 75-А, 76-С, 77-А, 78-С, 79-В, 80-В, 81-В, 82-А, 83-А, 84-А, 85-В, 86-Д, 87-Е, 88-Е, 89-А, 90-В, 91-А, 92-В, 93-А, 94-Е, 95-Д, 96-Д, 97-А, 98-С, 99-В, 100-В,